



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

“Гадаадын иргэн, харьяатын газрын төв байрны
биеийн тамирын байгууламжийг ашиглах журам”-ыг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, төлөвлөгөөт биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах, ашиглалтыг сайжруулах зорилгоор “Гадаадын иргэн, харьяатын газрын төв байрны биеийн тамирын байгууламжийг ашиглах журам”-ыг хавсралтад дурдсанаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Д.Давааням), Хангалт үйлчилгээний хэлтэс (Г.Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/529 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

172200594

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2022 оны 06 дугаар тушаалын 13-ны өдрийн
А/95 дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ТӨВ БАЙРНЫ БИЕЙН ТАМИРЫН БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяатын газар (цаашид “байгууллага” гэх)-ын биеийн тамирын байгууламжийг ашиглах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Биеийн тамирын байгууламжид дараах заал, танхим, тоног төхөөрөмж багтана. Үүнд:

- Спортын заал
- Бялдаржуулах танхим
- Саун, амралтын өрөө
- Ширээний теннис
- Агаарын теннис тус тус хамаарна.

Хоёр. Биеийн тамирын байгууламжийн ашиглалт

2.1. Байгууллагын Хангалт үйлчилгээний хэлтэс биеийн тамирын байгууламж (цаашид “байгууламж” гэх)-ийг хариуцаж, түүнд Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн ахлах мэргэжилтэн хяналт тавина.

2.2. Биеийн тамирын байгууламжийн заал, өрөө, танхим тус бүрд явагдах тухайн жилийн арга хэмжээ, тоглолтын цагийн хуваарийг Хангалт, үйлчилгээний хэлтсийн дарга жил бүрийн 01 дүгээр сарын 25-ны дотор баталж, байгууллагын хэмжээнд мэдээлнэ.

2.3. Цагийн хуваарьт байгууллагын биеийн тамир, спортын болон бусад арга хэмжээ, газрын ажилтан, албан хаагчид болон гэрээт иргэн, аж ахуй нэгжийн тоглолт, бэлтгэл болон бусад арга хэмжээг тусгасан байна.

2.4. Байгууламжийн заал, өрөө, танхимуудын өдөр тутмын ашиглалтыг цагийн хуваарьт тусгана.

2.5. Хангалт үйлчилгээний хэлтсийн байгууламж хариуцсан биеийн тамирын арга зүйч (цаашид “байгууламж хариуцсан ажилтан” гэх) нь байгууламжийн ашиглалтын бүртгэлийг хөтөлж, заал, танхим, биеийн тамирын хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.6. Байгууламжийн техник, хэрэгслүүдийн аюулгүй ажиллагаа, эдэлгээнд тогтмол хяналт тавьж, хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон, эвдэрч гэмтсэн эд зүйлсийг акт үйлдэн, солиулахыг Хангалт, үйлчилгээний хэлтсийн байгууламж хариуцсан ажилтан хариуцна.

2.7.Тэмцээн, тоглолт, бусад арга хэмжээний үеийн биеийн тамирын хэрэгсэлтэй харьцах аюулгүй байдал, дэг журмыг байгууламжийг ашиглаж буй иргэн, аж ахуй нэгж бүрэн хариуцна.

2.8.Байгууламж хариуцсан ажилтан арга хэмжээний өмнө албан хаагч, аж ахуй нэгжид зааварчилгаа өгч, дотоод журмыг танилцуулан, биеийн тамирын хэрэгслүүдийг хүлээлгэн өгч, буцаан авахдаа шалгаж хүлээн авна. Хохирлыг буруутай этгээд барагдуулаагүй бол байгууламж хариуцсан ажилтан хохирлыг барагдуулна.

2.9.Ажлын цагаар спорт, биеийн тамирын арга хэмжээ явуулахгүй байхыг эрмэлзэх бөгөөд зайлшгүй тохиолдолд байгууллагын үйл ажиллагаанд саад болохгүй байх зохион байгуулалтыг хийж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу явуулна.

2.10.Гэрээт иргэн, аж ахуй нэгжийн буруутай үйл ажиллагаанаас техник, хэрэгслийг ашиглах боломжгүй болсон, эвдэрсэн, гэмтсэн бол хохирлыг хохирол учруулагч барагдуулна.

2.11.Байгууламжийн саунаар гаднын иргэдэд үйлчлэхгүй бөгөөд зөвхөн байгууллагын албан хаагчдад үйлчилнэ.

2.12.Байгууллагын удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа байгууллагуудын арга хэмжээг албан ёсны батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж болно.

Гурав. Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---